



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/166

Бат-Өлзий сум

Газар эзэмших эрхийг хүчингүй болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт “Их сумт хайрхан” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг эзэмшиж буй 6221002634 нэгж талбарын дугаартай 2 га газар нь Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг зөрчсөн тул газар эзэмших эрхийг хүчингүй болгосугай.

2. Газар эзэмших эрх, эрхийн гэрчилгээг нь хүчингүй болгосон талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэх, холбогдох гэрээ, гэрчилгээг хууль журмын дагуу цуцлахыг Газрын даамал (И.Маралмаа)-д даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын “Газар эзэмшүүлэх тухай” 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн А/111 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН